

Дүйцэлгүй үгсийг орчуулах үндсэн аргууд

Батмөнхийн Лхасүрэн 

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн
Англи, герман хэлний тэнхимийн багш, магистр, Улаанбаатар, Монгол Улс

Хүлээн авсан - Received:
2023-11-15

Засварласан - Revised:
2023-12-17

Хэвлэгдсэн - Published:
2023-12-26

lkhasuren@msue.edu.mn

ORCID: [0009-0001-3853-2737](https://orcid.org/0009-0001-3853-2737)



© 2023, Author(s)

Хураангуй: Мэдээллийн эрин үе болох XXI зуунд техник, технологийн дэвшил нэн хурдацтай өрнөж байна. Үүнтэй холбоотойгоор олон үг харь хэлнээс монгол хэлэнд тогтмол орж ирж буй. Ялангуяа 1990 оноос хойш дэлхийн шинжлэх ухааны зонхилох хэл болсон англи хэлнээс монгол хэлэнд шууд орж ирж буй шинэ үг, хэллэг, нэр томъёог монгол хэл рүү хэрхэн оновчтой хөрвүүлэх нь тулгамдсан асуудал юм. Үгийн сангийн хувьд орчуулгын тохироог бүрэн ба заримдаг хэмээн ялган үзвэл бүрэн тохироот үгс аль ч хэлний үгийн сангийн цөөн хувийг эзэлнэ. Эх хэлээр харилцагсдын соёл, ахуйн ялгаанаас хамааран орчуулгын хэлэнд үгийн сангийн үлдэх хувь буюу ихэнх нь орчуулгын бүрэн биш тохироонд хамаардаг. Иймд уг өгүүлэлд дүйцэлгүй буюу эквивалентгүй үгсийг оновчтой орчуулахад эзэмших шаардлагатай орчуулгын үндсэн аргуудыг авч үзэв.

Түлхүүр үг: Реали, үсэглэх, галиглах, тайлбарлах, хуулбарлан орчуулах, ойролцоо орчуулга

Удиртгал

XXI зууны *Тогтвортой хөгжлийн зорилт 4-Боловсрол 2030* хөтөлбөрийн хүрээнд мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ)-ийг боловсролын чанарыг сайжруулах гол хөшүүрэг хэмээн тодорхойлсон (ЮНЕСКО, 2021: 5). Улмаар уг техник, технологийн үсрэнгүй хөгжил өрнөж буй эрин үед шинжлэх ухаан, боловсрол зэрэг нийгэм, соёлын бүх салбарт харь хэлнээс ялангуяа англи хэлнээс монгол хэлэнд шинэ үг, хэллэг, нэр томъёо ихээхэн орж ирж буй. Иймд эх хэлнээс орчуулгын хэлэнд буюу монгол хэлэнд тухайн харь үгсийг оновчтой орчуулж нутагшуулах зайлшгүй хэрэгцээ шаардлага тулгарч байна.

“Орчуулга” гэдэг ухагдахууныг хамарсан үйл ажиллагаа нэн өргөн хүрээтэй. Аль ч төрлийн орчуулгыг ямар ч мэдлэг чадвартай орчуулагч хийсэн нь хамаагүй тэр орчуулгад зайлшгүй хоёр үндсэн шаардлага тавигддаг.

- a) Орчуулж байгаа зорилго бол тухайн хэлийг мэдэхгүй хүнд эх зохиол буюу ярьж байгаа хүний бичсэн ярьсныг аль болохуйц үнэн зөв, ойр дөт ойлгуулахад чиглэгддэг.
- b) Орчуулна гэдэг бол урьд өмнө аль нэг хэлээр бичиж туурвисан зүйлийг нөгөө хэлний буюу орчуулга хийж буй хэлний хэрэглэгдэхүүнийг ашиглан бүрэн төгс илэрхийлэн гаргах их хариуцлага юм. Энэ утгаар нь авч үзвэл жинхэнэ орчуулга бол агуулгаар нь тайлбарлах, хялбарчлан хэлмэрчлэх, товчлох хэлбэрүүдээс эрс ялгаатай.

Үүнээс үндэслэн орчуулга бол нэг хэлээр илэрхийлсэн санааг нөгөө хэлний бүх хэрэглэгдэхүүнийг ашиглан бүрэн төгс гаргах бүтээлч хөдөлмөрийн үр дүн мөн (Гүрбазар, 1996: 5). Хэлний бүх хэрэглэгдэхүүн гэдэгт авиа зүй, үгийн сан, өгүүлбэр зүй, найруулга зүйд хамаарах бүх хэрэглүүр багтана. Орчуулагч бол зөвхөн орчуулга хийж байгаа хэлний хэрэглэгдэхүүн төдийгүй орчуулгад оролцож байгаа эх хэл, орчуулга хийж байгаа хэл хоёрын хоёулын хуулийг бүрэн эзэмшсэн байх шаардлагатай (Гүрбазар, 1996: 6).

Аливаа бичиг зохиолыг орчуулахын тулд орчуулагч хүн гадаад хэлээр байгаа зохиол бүтээлийг өөрийн уугуул хэлээр бичсэн шиг хөдөлбөргүй ухаарч мэдсэн байх, нөгөө талаар орчуулж байгаа хэлээр түүнийгээ бүрэн зөв, яруу тод, оновчтой илэрхийлэн гаргасан байх учиртай.

Орчуулгын онол бол орчуулагчийн бүтээлч ажиллагааг задлан шинжилж орчуулгад оролцсон хоёр болон түүнээс дээш хэлний хоорондын харьцаа, орчуулагчийн арга барилыг судлан орчуулгын зүй тогтлыг илрүүлдэг бие даасан ухаан.

Орчуулгыг хэлбэрээр нь дараах дөрвөн төрөлд хуваана. Үүнд:

- 1) *Төрөл* /монгол-буриад-халимаг, орос-слав, франц-итали-испани-португали/ хэл хооронд орчуулах болон *төрөл бус* /монгол-англи, франц-хятад, араб-орос гм/ хэл хооронд хийх орчуулга.
- 2) Утга зохиолын хэлнээс нутгийн аялгуу /монголын утга зохиолын хэлнээс торгууд аялгуу/-нд хийх орчуулга.

Харин нутгийн аялгуунаас үндэсний утга зохиолын хэлээр хийх орчуулга нь ихэвчлэн эрдэм шинжилгээний зориулалттай байдаг.

- 3) Эртний буюу хуучин хэлнээс орчин цагийн утга зохиолын хэлэнд хийх орчуулга /*Монголын нууц товчоо, Chanson de Roland, Слово о полку Игореве* зэрэг эртний сонгодог зохиол бүтээлийг орчин үеийн утга зохиолын хэл рүү орчуулсан олон хэлбэрийн орчуулга/.

- 4) Хүн төрөлхтний хэлнээс шинжлэх ухааны тодорхой салбарын *тэмдэгтүүдэд шилжүүлсэн орчуулга* /химийн томъёо, одон орон судлалын ба замын тэмдэгт/.

Гэхдээ бүх төрлийн орчуулгад хүмүүсийн харилцааны гол хэрэглүүр болсон хүн төрөлхтний хэл гол үүрэг гүйцэтгэдэг. Ийм учраас нэг хэлээр байгаа зохиол бүтээл буюу үг хэллэгийг нөгөө хэлээр уншигч буюу сонсогч хүнд хамгийн дөт дөхөм, ойлгомжтой, бүрэн зөв илэрхийлэн гаргах нь аль ч төрөл хэлбэрийн орчуулгын үндсэн үүрэг байдаг (Гүрбазар, 1996: 7).

Үүнтэй холбоотойгоор орчуулгын явцад орчуулгад оролцож байгаа хоёр ба түүнээс дээш хэлний үг хоорондоо хэрхэн тохирохыг зөв шийдвэрлэх нь орчуулга судлалын зангилаа асуудлын нэг мөн. Үгийн сангийн тохироог *бүрэн, бүрэн бус /заримдаг/* гэж ялган үзэж болно (Гүрбазар, 1996: 88). Эх зохиолд гарч буй үг орчуулж байгаа хэлний үгтэй утга санаа, баримжаагаараа аль алианаа гүйцэт орлохуйц үгсийг бүрэн тохироо /оноолт/ гэж үзэж байна. Ийм үгс аль ч хэлний үгийн сангийн цөөн хувийг эзэлнэ. Бүрэн тохироонд цаг тооны бичгийн сар /January, February/, гарагийн нэр /Sunday, Monday/, оноосон нэр, газар усны нэр, шинжлэх ухаан, техникийн нэр томъёо (electromagnet, half-conductor, atom weight, consumption object), ургамал, амьтны нэрийтгэл нэр /camel, squirrel, cherry/ ураг төрлийн нэрийтгэл нэр /son, daughter/, албан байгууллагын нэр /НҮБ/- ийг багтаан хэлэлцэж болно.

Гэхдээ орчуулагчид ийм бүрэн тохироонд найдах учиргүй, учир нь аль ч хэлний үгийн сангийн үлдэх хувь буюу ихэнх нь орчуулгын бүрэн биш тохироонд хамаардаг. Нэг хэлний нэг үгийг нөгөө хэлний хэд хэдэн үгээр орчуулах буюу оноох тохиолдол хамгийн түгээмэл үйл явц болно. Ямар ч хэлний үг олон салаа утгатай, тэгэхдээ нэг хэлний үгийн олон салаалсан утгын тогтолцоо нөгөө хэлний тийм тогтолцоотой огт тохирдоггүйд хамаг учир оршино (Гүрбазар, 1996: 90-91).

Ийм түгээмэл тохиолддог орчуулгын бүрэн биш тохироог судлаач Цэеэрэгзэн, Хосбаяр, Ариунаа, Батцэцэг (2002) нарын бүтээлд эквивалентгүй үг хэмээн нэрлэсэн ба эдгээрийн ангилал, шалтгаан, мөн чанарыг дараах байдлаар авч үзжээ. Нэг хэлэнд орших үг, хэллэг нь нөгөө хэлэнд үгсийн сангийн түвшинд дүйцэх үггүй байж болно. Ийм үгийг эквивалентгүй үг гэж нэрлэдэг. Эквивалентгүй үг орчуулгад тохиолдох нь хэд хэдэн үндсэн шалтгаантай байдаг. Шалтгааныг мэдэж байх нь орчуулгын явцад тохиолдох бэрхшээлийг даван туулж, эквивалентгүй үгийн утгыг ямар нэгэн аргаар орчуулгын хэл рүү дамжуулах боломж олгох юм.

1. Реали (үндэсний онцлог) үгс

Эх хэлээр харилцагсдын соёл, ахуйд оршин байгаа бодит юмс, үзэгдэл, ойлголт орчуулгын хэлээр харилцагсдын соёл, ахуйд байхгүй байх тохиолдол элбэг ажиглагддаг (Цэеэрэгзэн ба бус, 2002: 30). Өөрөөр хэлбэл тухайн улс орон, ард

түмний амьдрал ахуй, зан заншил, соёл иргэншил, нийгмийн байгууллын онцлогийг тусгасан эд өлөг, үзэгдлийн нэр агуулгыг тэр улс түмний хэлээр илэрхийлсэн бөгөөд бусад хэлээр орчуулж болшгүй үг, нийлэмж үгийг үндэсний онцлог үг “realis” /хожуу үеийн латины “эд юмс, эд өлөг” гэсэн утгатай/ гэж нэрлэж байна (Гүрбазар, 1996: 110). Жишээ нь монгол хүн бүхний сайн мэддэг бүслүүр, өрх, тооно, унь, гэрийн хана зэрэг бодит юмс нь англи, герман, франц, япон зэрэг хэлээр харилцагчдын амьдрал ахуйд нь байхгүй учир эдгээр хэлэнд монгол гэрийн хэсгүүдийг нэрлэсэн дээрх үгтэй дүйцэх эквивалент үг, хэллэг байхгүй юм. Үүнтэй нэгэн адил японы үндэсний хоол болох суши, сашими зэрэг үгсийн шууд дүйцэл нь монгол хэлэнд байхгүй юм.

Мөн АНУ-д “drive-in” хэмээн үйлчлүүлэгчдийг автомашинаас нь буулгахгүй үйлчилдэг олон төрлийн үйлчилгээ байдаг бөгөөд эдгээр нь бусад оронд байдаггүй.

2. Түр зуур эквивалентгүй үг, хэллэг

Эдгээр үг нь реали үгтэй нийгмийн шалтгааны хувьд нэлээд төстэй. Өөрөөр хэлбэл эх хэлээр харилцагчдын нийгмийн амьдралд оршин байгаа эд зүйл, ойлголт орчуулгын хэлээр харилцагчдын амьдрал ахуйд хараахан нэвтрээгүй байж болно. Ингээд соёл, техник, нийгмийн амьдралд өөрчлөлт гарахад эдгээр юмс үзэгдэл нэвтрэн орж ирээд үүний зэрэгцээ юмс үзэгдлийг нэрлэсэн үг хэллэг нь хамт орж ирдэг. Жишээ нь, internet-café/ интернэт кафе, hamburger/ хамбургер, гамбург, play off/ плей-оффын тоглолт гэх мэт жишээ өнөөгийн монгол хэлэнд олон байна.

3. Санамсаргүй тохиолдлоор эквивалентгүй болсон үгс

Эх хэл ба орчуулгын хэлээр харилцагч ард түмний аль алиных нь ахуй амьдралд бодитойгоор орших юмс үзэгдэл байвч эх хэлэнд энэ нь үгсийн сангийн нэгжээр илрээд, харин орчуулгын хэлэнд тодорхой бус шалтгаанаар үгсийн сангийн нэгжээр нэрлэгдээгүй байх тохиолдол бас байдаг. Ийм үгийг санамсаргүй эквивалентгүй үг гэдэг. Жишээ нь, монгол хэлэнд *их үд, бага үд* гэж ялгадаг байхад, орос хэлэнд ингэж ялгалгүй зөвхөн *полдень* гэж хэлдэг.

4. Бүтцийн хувьд эквивалентгүй үгс

Эх ба орчуулгын хэлээр харилцагчдын аль алиных нь ахуй амьдралд байдаг хэр нь эх хэлэнд тодорхой үгээр илрээд, харин орчуулгын хэлэнд үгээр илрээгүй юмс үзэгдэл, ойлголт байдаг. Гэхдээ бүтцийн хувьд эквивалентгүй үгийг орчуулгын хэлэнд чухам яагаад байхгүй байгааг нь тайлбарлаж болно. Жишээ нь орос хэлний *сочувствовать* гэсэн үг бий. Энэ үг нь үгчилбэл *хамтран мэдрэх* гэсэн утгатай бөгөөд а/ харилцан ярилцагч нь ямарваа нэгэн хүнд байдалд орсон тухайгаа хэлэхэд үүнийг би *хамтран мэдэрч байна* гэсэн утгаар хариуд нь хэлдэг үг. Үүнийг Ц.Дамдинсүрэн, А.Лувсандэндэв нарын *Орос монгол толь*-д хэрхэн дүйцүүлснийг үзье.

Сочувствовать.

1. Өрөвдөх, хөөрхийлөх, хайрлах;
2. Ойшоох, даган баясах, талархах;

Энэхүү үгийн хоёр хэлний толины дүйцэл нь үгийн үндсэн утгыг илэрхийлэн гаргаж чадаагүй байна.

Эквивалентгүй үгийн утгыг орчуулгаар дамжуулах аргууд

Эх хэлээр харилцагчдын хэрэглээнд байгаа юмс, үзэгдэл ойлголт нь орчуулгын хэлээр харилцагчдын нийгэм, ахуйн хэрэглээнд байхгүй учир эдгээр юмс, үзэгдэл, ойлголтыг заасан үг, хэллэг нь орчуулгын хэлэнд байдаггүйг бид мэднэ. Өөрөөр хэлбэл, эх хэлэнд буй эдгээр үг нь орчуулгын хэлний хувьд эквивалентгүй үг юм. Энэ нь эквивалентгүй үгийн утгыг орчуулгын хэл рүү дамжуулж болохгүй гэсэн үг биш. Орчуулгын практикт эквивалентгүй үгийн утгыг орчуулан дамжуулах дараах аргуудыг хэрэглэдэг.

I. Үсэглэх (үсэгчлэн галиглах) транслитерацийн арга (Transliteration- writing by letters) /латины trans-дамжуулах, нэвт, -аар, -ээр; litera-үсэг/

Энэ нь эх хэлний үгийн үсгийн тэмдэглэлийг орчуулгын хэлний үсгийн тэмдэглэлээр дамжуулан буулгах арга юм. Өөрөөр хэлбэл, эх хэлний үгийг зээлдэн авч байгаа гэсэн үг юм (Цэвэрэгзэн ба бус, 2002: 31). Транслитерацийн аргыг мөн үсэгчлэн галиглах буюу нэг хэлний цагаан толгойн үсгийг нөгөө хэлний нийцэх цагаан толгойн үсгээр хөрвүүлнэ (Мягмарсүрэн, 2021: 19) хэмээн тодорхойлох нь бий. Жишээ нь virtual /'vз:ʃuэл/- виртуал.

Энэ арга нь сайн, муу хоёр талтай. Сайн тал нь гэвэл орчуулагч уг үгийн гадаад хэлбэрийг тэр чигээр нь дамжуулаад, ингэснээр уг үгийг буруу ойлгох, тайлбарлах аюулыг зайлуулдаг. Уншигч нь үгийн утгыг контекст /хам сэдэв/-ээр нь дамжуулан ойлгоно. Дутагдалтай тал нь гэвэл уншигчийн хувьд шинэ үгийн утга санаа дутуу ойлгогдох, эсвэл нэлээд ойролцоо байдлаар ойлгогдож болох юм. Ийм байдал гаргуулахгүйн тулд орчуулагч хаалтад нэмэлт тайлбар хийж болно. Гэхдээ энэ нэмэлт тайлбар нь орчуулгын бие даасан арга учир, нэг зэрэг хоёр арга хослуулан хэрэглэж байгаа гэсэн үг юм.

Мөн транслитерацийн аргаар гадаад хэлнээс орж ирж буй үгс нь төрөлх хэлийг бохирдуулдаг гэсэн үзэл байдгийг энд тэмдэглэх хэрэгтэй.

Бид олон арван жилийн турш орос хэлээр орос болон бусад хэлний үгийг транслитерацийн аргаар дамжуулан авсан юм. Ингэхэд орос ба монгол хэлний үсэг ижил байгаа явдал нь ямар ч гадаад үгийг дуудлага үл харгалзан орос хэлэнд бичдэгийг яг тэр чигээр нь хуулж авч байсан билээ. Жишээ авч үзье:




Японоос-кимоно, сакэ, каратэ

Англиас-микрософт, радио, принтер

II. Галиглах (авиачлан галиглах) транскрипцийн арга /transcription: латины transcriptio- хуулан бичилт/

Энэ арга нь дээрхтэй төсөөтэй боловч зарчмын ялгаатай. Транслитерацийн аргаар буулгахад үсгийг дүйцүүлэн орлуулж тавьдаг бол, транскрипцийн аргаар буулгахад уг үгийн эх хэлэн дэх дуудлагыг харгалздаг (Цэвэрэгзэн ба бус, 2002: 32).

Мөн уг аргыг судлаач Т.Мягмарсүрэн (2021) авиачлан галиглах хэмээн нэрлэжээ (Мягмарсүрэн, 2021: 19). Өөрөөр хэлбэл галиглах/транскрипци гэдэг нь өөрийн хэлний үсэг ашиглан гадаад хэлний авиаг тэмдэглэхийг хэлдэг (Гүрбазар, 1996: 106). Жишээлбэл: *online-онлайн, digital-дижитал, internet-интернэт*-транскрипци буюу транслитерацийн арга; *polo-поло* транскрипци буюу транслитерацийн арга



Оноосон нэр /хүний нэр, хот, уул, гол мөрөн, сонин сэтгүүл, байгууллага г../-ийг мөн транслитераци ба транскрипцийн аргаар буулгадаг.

Зарим тохиолдолд газар зүйн холбогдолтой нэрийг

- а) Авиан зүйн хувиргалд оруулж бичих, эсвэл, б/ орчуулгын хэлэнд байдаг өөр хувилбарыг ашиглах явдал бас бий.

Кяхта- Хиагт

Иркутск- Эрхүү Авиан зүйн хувилбартай аргууд

Эрлянь- Эрээн

Амур- Амар

Волга /мөрөн/- Ижил /мөрөн/- тусгай дүйцэх үг байх тохиолдол (Цэеэрэгзэн ба бус, 2002: 32).

Гэхдээ эрдэм шинжилгээний зохиол бүтээлд үсэгчлэхээс бусад тохиолдолд галиглах аргыг зонхилон хэрэглэдэг. Жишээ нь Alexander- Александр, John- Жон, Ann-Анна. Ер нь хүний нэрийг олон янзаар галиглах явдал түгээмэл байдаг. Жишээлбэл, Английн нэрт зохиолч Ж.Голсуорсийн /Galsworthy, 1867- 1933/ нэрийг 144 хувилбараар галиглаж болох юм гэж орос эрдэмтэд тэмдэглэсэн нь бий (Гүрбазар, 1996: 106).

III.Кальк буюу хуулбарлан орчуулах арга /фр. calque- дуурайх/

Эх хэлэн дэх үгийн сангийн нэгж болох үг буюу хэллэгийн бүрэлдэхүүн хэсгийг /бүтээвэр, язгуур, үндэс, үг/ шууд үгчлэн орчуулж буулгах арга юм. Жишээ нь анх герман хэлнээс гаралтай

Kindergarten – детский сад – хүүхдийн цэцэрлэг

Geschäftsbank – коммерческий банк – арилжааны банк

Англи хэлний дараах үгсийг мөн хуулбарлаж орчуулжээ. Жишээлбэл:

Steamboat – пароход – уурын хөлөг

Skyscraper – небоскреб – тэнгэр баганадсан барилга

Франц хэлэнд *prendre les mesures* гэж хэлдгийг *to take measures – принять меры – арга хэмжээ авах* хэмээн хуулбарлан орчуулжээ. Ингэж хуулбарлах буюу үгчилж орчуулах нь тухайн хэлний үгийн санд шинэ соргог үг, хэллэг нэвтрүүлэх эерэг боломж бий болгож байгаа боловч гадаад хэлний үг, нийлэмж үг бүрийг ингэж хуулбарлаад байвал үгчлэх орчуулга руу хэлбийсэн гаж буруу арга барилыг дэмжсэн хэрэг болно (Гүрбазар, 1996: 112).

IV.Ойролцоо орчуулга

Эх хэлний реали үгний оронд орчуулгын хэлний утгын хувьд тодорхой хэмжээгээр дүйцэх мөн реали үгийг авч хэрэглэх тохиолдол байдаг. Ийм орчуулга нь

бүрэн дүйцлийг хангаж чадахгүй боловч, утгыг тодорхой хэмжээгээр дамжуулж байгаа учир орчуулагчид хэрэглэдэг байна. Жишээ нь: *Santa Klaus – Sant Nikolaus, Дед Мороз – Өвлийн өвгөн, Drugstore – эмийн сан.*

Тухайн үед орос ард түмний хатуу сархад болох *водка* монголд орж ирэхэд ойролцоогоор дүйцэх монголын үндэсний сүүний гаралтай бага градустай сархдыг нэрлэдэг *архи* гэдэг үгээр монголчууд орчуулсан нь одоо нэгэнт хэвшсэн нэр болжээ. Гэтэл оросын энэ ундааг бусад улс транскрипцийн аргаар *vodka* хэмээн нэрлэдэг байна (Цэеэрэгзэн ба бус, 2002: 32-33).

Английн *shock-worker*, францын *travailleur de choc*, германы *stossarbeiter*, испанийн *obrero de choque* гэдэг үг нь утгаа орос хэлний *ударник* /тэргүүний ажилчин/ гэсэн үг. Үүнийг дээрх хэлнүүдээр яг үгчлэн орчуулж үгийн сангийнхаа бүрэлдэхүүн хэсэг болгосон байхад монголоор ойролцоо утгатай үгийг ашиглан *гавигай ажилчин* гэж орчуулдаг.

V.Тайлбарлан орчуулах арга

Энэ нь эквивалентгүй үгийн утгыг дэлгэрэнгүйгээр тайлбарлан гаргахыг хэлнэ. Энэ аргыг хэрэглэхэд үгийн утга бүрэн тайлбарлагддаг тул уншигчдад илүү ойлгоцтой байдаг. Жишээ нь, оросын *борщ* гэдэг үгийг хүрэн манжинтай ногоотой шөл гэж тайлбарлан орчуулсан байдаг. Судлаачид (Цэеэрэгзэн ба бус, 2002: 33) монгол хэлний *тооно* гэдэг үгийг *дымовое отверстие в верхней части юрты* хэмээн орчуулсан бол орчуулагч С.Өлзийжаргал *a wooden ring to put on* (Oyungerel, 1999: 31) хэмээн англи руу тайлбарлаж буулгажээ. Монгол хэлний *боодог* гэдэг /реали/ үндэсний онцлог үг хэллэгийг *boodog is one of delicacies. For making boodog the goat meat or mutton is cut into pieces and cooked in an animal skin from the inside out, by placing hot rocks inside* хэмээн орчуулагч С.Өлзийжаргал транслитераци буюу транскрипци болон тайлбарлан орчуулах аргыг хослуулан англи хэл рүү ойлгомжтой хөрвүүлжээ (Oyungerel, 1999: 32).

Дүгнэлт

Мэдээлэл харилцааны технологи үсрэнгүй хөгжсөнөөр техник технологийн дэвшил дэлхий даяар хурдацтай тархаж буй XXI зуунд шинжлэх ухаан, боловсрол зэрэг нийгэм, соёлын бүх салбарт харь хэлнээс, ялангуяа англи хэлнээс монгол хэлэнд шинэ үг, хэллэг, нэр томьёо ихээхэн нэвтэрч орж ирсээр байна. Орчуулга нь нэг хэлээр илэрхийлсэн санааг нөгөө хэлний бүх хэрэглэгдэхүүнийг ашиглан бүрэн төгс гаргахыг шаарддаг. Иймд эх хэлнээс орчуулгын хэл рүү шинэ үг, хэллэг, нэр томьёог хэрхэн оновчтой хөрвүүлэх нь тулгамдсан асуудал юм. Үгийн сангийн хувьд орчуулгын тохироог бүрэн ба бүрэн бус хэмээн үзэх ба бүрэн тохироот үгс аль ч

хэлний үгийн сангийн цөөн хувийг эзэлнэ. Эх хэлээр харилцагсдын соёл, ахуйн ялгаанаас хамааран орчуулгын хэлэнд үгийн сангийн үлдэх хувь буюу ихэнх нь орчуулгын бүрэн биш тохироонд хамаардаг. Эдгээр эквивалентгүй үгийг оновчтой орчуулахад орчуулгын практикт үсэглэх, галиглах, хуулбарлан орчуулах, ойролцоо орчуулга, тайлбарлан орчуулах гэсэн орчуулгын үндсэн аргуудыг дангаар нь болон хослуулан ашигладаг байна. Өнгөрсөн хугацаанд ямар ч гадаад үгийг дуудлага үл харгалзан орос хэлэнд бичдэг яг тэр чигээр нь монгол хэлэнд хуулж авч байсан. Харин сүүлийн 30 орчим жилд англи хэлнээс монгол хэл рүү эквивалентгүй үгсийг дээрх үндсэн аргуудаар орчуулан хэрэглэж байна. Иймд цаашид харь хэлний үг, хэллэг, нэр томъёог монгол хэл рүү хөрвүүлэхдээ нэг бүрчлэн нягтлан хянаж, оновчтой хувилбарыг нь сонгон авч хэрэглэж занших зайлшгүй хэрэгцээ шаардлагатай тулгарч байна.

The Main Techniques of Translating Non-equivalent Words

Lkhasuren Batmunkh

*English and German languages Department, Mongolian National University of Education
Ulaanbaatar, Mongolia*

Abstract: The technological advances are occurring at a rapid pace in the 21st century which is called the age of information technology. Regarding these advancements, many new foreign words are entering Mongolian language constantly. Especially since 1990, the challenge has been how to translate new words, phrases and terms into Mongolian accurately from English, the main international academic language. In terms of lexical equivalence, it can be complete and partial. The issue is partial equivalence outnumbers absolute equivalence in any language depending on the cultural differences of speakers of a source language. In order to translate those non-equivalent vocabulary items, the main translation techniques such as transliteration, transcription, calque or loan translation, substitution and description are used individually and collectively. In the past, we used to spell and translate any foreign word from Russian into Mongolian as they were spelt in Russian irrespective of its pronunciation. But in the last 30 years we have been translating non-equivalent vocabulary from English into Mongolian by the main techniques mentioned above. Therefore, in the future, there is a necessity of choosing and using the best translated version of a foreign word, phrase and terms after the translation of each and every foreign word is being checked carefully.

Keywords: Realis, transliteration, transcription, amplification, calque, generalization

Ном зүй

- Батсайхан, Б., Дэлгэржав, М. (2019). *Боловсрол судлалын тайлбар толь (англи-орос-монгол)*. Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Гүрбазар, Р. (1996). *Орчуулгын онол, дадлагын үндэс*. Улаанбаатар.
- Мягмарсүрэн, Т. (2021). Үсэгчлэн галиглах арга, түүнийг хэрэглэхтэй холбоотой зарим асуудал. *Орчуулга зүй*, 9 (559), 18-25.
- Oyungere, Kh. (1999). *Mongolia Travel Guide*. Ulaanbaatar: Gobiin Ogloo.
- Цэвэрэгзэн, Р., Хосбаяр, С., Ариунаа, Ч. Батцэцэг, Д. (2002). *Орчуулгын хэрэглээний онол, дадлагын гарын авлага Модуль 1*. Улаанбаатар.
- Чоймаа, Ш., Батдорж, Ц., Шинэбаяр, О., Тунгалаг, Ж., Батчимэг, Н., Нарантуяа, С., Даваа, Ж. (2019). *Дээд боловсролын нэр томъёоны монгол-англи-орос тайлбар толь*. Улаанбаатар: Сод пресс.
- ЮНЕСКО. (2021). *Монгол улсын боловсролын салбар дахь мэдээлэл харилцаа холбооны технологийн бодлогын тойм шинжилгээ*. <https://unesco.mn/mn/wp-content/uploads/2022/05/ICT-in-Education-Policy-Review-Report-mongolian-1013-1.pdf>